



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 342

Номгон


Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 45, 115, 118, 154 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны А/291 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 45 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж байгаатай холбогдуулан коронавируст халдвар тархах эрсдэлээс иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 24:00 хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж, халдвар хамгааллын арга хэмжээг олон нийтэд мөрдүүлсүгэй.

2. Халдварын тархалтын "Улбар шар" түвшинд шилжсэн хугацаанд холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010873